

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

/2011 оны эхний хагас жилийн байдлаар/

I. ТӨСӨВ: Аймгийн төсвийн орлогод 3.9 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө нь 125.2 хувиар биелсэн байна.

Баруун-Уртаас бусад бүх сумдын төсвийн орлогын төлөвлөгөө нь 5.0-44.2 хувиар давж биеллээ.

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилт 4.2 тэрбум төгрөг болж, төлөвлөгдсөн хэмжээнээс 1.0 тэрбум төгрөгөөр хэтэрчээ.

Эхний хагас жилд 983.5 сая төгрөгийн төсвийн хөрөнгө оруулалт хийгдсний дотор 403.1 сая төгрөг нь нийгэм бие хүнд үзүүлэх үйлчилгээнд, 307.2 сая төгрөг нь төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын салбарт, 219.4 сая барилгын салбарт, 48.6 сая төгрөг нь эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбарт, 5.2 сая төгрөг нь ХАА-н салбарт тус тус оржээ.

II. МӨНГӨ, ЗЭЭЛ: Монгол банкны мэдээгээр ХААН, Хадгаламж, Хас, Голомт банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 26.5 тэрбум төгрөгт хүрсэн нь 2010 оны жилийн эцсээс 6.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн хадгаламжийн хэмжээ 15.6 тэрбум төгрөг болсон нь 2010 оны жилийн эцсээс 4.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

III. ХӨДӨӨ АЖ АХУЙ: Мал аж ахуй: Оны эхний төллөх эх малын 83.6 хувь болох 718.1 мянган эх мал төллөж, гарсан төлийн 99.1 хувь болох 716.5 мянган төл бойжиж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 76.6 мянгаар дээгүүр байна.

Оны эхний малын 2.2 хувь болох 44.8 мянган том мал зүй бусаар хорогдож, малын онд оролт 97.8 хувьтай байна.

Хорогдлын 50.2 хувийг ямаа, 39.3 хувийг хонь эзлэж байна. Асгат, Эрдэнэцагаан, Дарьганга, Наран сумдад оны эхний малын 9,43-4,38 хувь нь хорогдож, малын онд оролт 90.6-95.6 хувьтай байна.

Тариалалт: 63.7 га-д төмс, 30.2 га-д хүнсний ногоо тариалсан нь урьд оны мөн үеэс 8.3-11.1 хувиар дээгүүр байна.

IV. АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 13.4 тэрбум төгрөг болж урьд оны мөн үеийнхээс 361.7 сая төгрөгөөр доогуур, оны үнээр 54.9 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 3.4 тэрбум төгрөгөөр доогуур гүйцэтгэлтэй байгаа бөгөөд энэ нь уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт үйлдвэрлэлт, борлуулалт 11.9-7.6 хувиар доогуур гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс талх, хиам, замын хавтан, боржуур, дулаан үйлдвэрлэлт урьд оны мөн үеэс дээгүүр үзүүлэлттэй байна.

V. БАРИЛГА, ТЭЭВЭР, ХОЛБОО: Барилга: Барилгын 8 байгууллага улсын төсвийн хөрөнгөөр 433.9 сая төгрөгийн, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 474.0 сая төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсэн нь урьд оны мөн үеэс дээгүүр байна.

Тээвэр: Тээвэр бүхий байгууллагууд 25571.5 мян.тн.км-ийн ачаа эргэлт, 5912.6 мян.хүн.км-ийн зорчигч эргэлт хийж, 3.0 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна.

Холбоо: Холбоо ашиглалтын орлого 165.7 сая төгрөг байгаагийн дотор 77.2 сая төгрөг нь хүн амаас орсон байна. Телефон цэгийн тоо 1590 болж урьд оны мөн үеэс 55.7 хувиар өссөн байна.

VI. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС: Хэрэглээний үнийн индекс 6-р сард өмнөх 2010 оны жилийн эцсийнхээс 2.7 хувиар өслөө.

Энэхүү өсөлтийн цаана гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 6.5 хувиар, тээврийн үнэ тариф 16.6 хувиар, бусад бараа үйлчилгээ 6.1 хувиар өссөн байна.

Хүнсний бараа, согтууруулах бус үндээ, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ, боловсролын үйлчилгээний үнэ, тариф жилийн эцэст байсан хэмжээндээ тогтвортой байна. .

VII. СОЁЛ, БОЛОВСРОЛ: Соёл: ХЖТеатр 11.6 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

Музей: 1.8 мянган үзмэрээр 2.7 мянган хүнд үйлчилж, 333.0 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна.

Нийтийн номын сан: 12.1 мянган уншигчдад 42.6 мянган номоор үйлчилж 501.5 мянган төгрөгийн орлоготой ажиллажээ.

Боловсрол: ЕБС-ийн 2010-2011 оны хичээлд 2604 хүүхэд төгссөний дотор 488 хүүхэд бүрэн дунд боловсролыг, 1061 хүүхэд суурь боловсролыг, 1055 хүүхэд бага боловсрол эзэмшлээ.

VIII. ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ: Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 2.5 тэрбум төгрөг болж төлөвлөгөөгөө 19.7 хувиар, сайн дурын даатгуулагчид 61.9 сая төгрөгний шимтгэл оруулж, төлөвлөгөө 15.5 хувиар тус тус давуулсан байна. 6009 өндөр настанд 4.0 тэрбум төгрөгийн тэтгэвэр, Нийгмийн халамжийн сангаас 0.7 тэрбум, улсын төсвөөс 8.2 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

IX. ЭРҮҮЛ МЭНД: Эхний 6 сард 609 эх амаржиж, 611 хүүхэд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс дээгүүр байна.

Халдварт өвчнөөр 281 хүн өвчилсөн нь урьд оны мөн үеэс 17-оор олон байгаа бөгөөд тэмбүү, заг, салхинцэцэг, мөөгөнцөр, трихоминиаз зэрэг өвчлөлүүд өссөн байна.

X. АЖИЛГҮЙЧҮҮД: ХХҮХэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1110 болж, эхний 6 сард 203-аар нэмэгдсэн байна. Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 79.7 хувь нь 16-34 насны залуучууд байна. Боловсролын хувьд 21.7 хувь нь дээд, 2.6 хувь нь тусгай дунд, 35.4 хувь нь бүрэн дунд, 7.7 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна.

Эхний 6 сард 1954 хүн шинээр бүртгүүлж, 1694 хүн ажилд орсны дотор шинэ ажлын байранд 628 хүн ажиллаж байна.

XI. ГЭМТ ХЭРЭГ: Эхний 6 сард 104 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 19-өөр дээгүүр байна. Гэмт хэргийн улмаас 21 хүн нас барж, 26 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 14.9 сая төгрөгийн хохирол учирсны 12.9 саяыг нь нөхөн төлүүлжээ.

Гэмт хэрэгт 109 хүн холбогдон сэжиглэгдсэний 16.5 хувь нь согтуугаар, 11.9 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна.

Нийт 1393 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеийнхээс 131 хүнээр олон байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 80 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

XII.МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛ ТӨСӨЛ: Төслийн хүрээнд 3 даатгалын нэгжийн төлөөлөгч ажиллаж, оны эхний 6 сард 9 сумын 154 өрхийн 33.7 мянган малыг даатгалд хамруулан, 14.9 сая төгрөгийн хураамж төвлөрүүлсэн байна.

XIII. ДААТГАЛ: Даатгалын байгууллагуудын хураамжийн орлогоор 65.9 сая төгрөг орж, төлөвлөгөө нь 28.7 хувиар тасарсан байна. 246 хүнд 13.2 сая төгрөгийн нөхөн төлбөр олгожээ. Үүнээс авто тээврийн хэрэгсэлд 7.2 сая, гэнэтийн осолд 3.9 сая, хөдөлмөрийн чадвар түр алдалт 1.6 сая, хүүхдийн гэнэтийн осолд 204.0 мянган төгрөгийг тус тус олгожээ.

XIV. ТӨСӨЛ: ХЭДСАН: Аймгийн хэмжээгээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 12 суманд 100.7 сая төгрөгийн зээл олгосны дотор Дарьганга суманд 23.0 сая, Уулбаян суманд 14.5 сая, Сүхбаатар суманд 12.5 сая, Эрдэнэцагаан суманд 10.1 сая төгрөгийн зээл олгосон нь хамгийн өндөр байна. **ТА-2 төсөл:** Тогтвортой амжиргаа II төслийн хүрээнд аймгийн хэмжээгээр 36.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, тохижуулалтанд 19.4 сая, бусад үйл ажиллагаанд 17.0 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

XV. ГАЗАР ӨМЧЛӨЛ: Оны эхний 6 сард 187 иргэн газар өмчилж авах өргөдөл өгсөнөөс 181 иргэний өргөдлийг шийдвэрлэж, 16 га газрыг өмчлүүлж, өссөн дүнгээр нийтдээ 5365 иргэн өргөдөл гаргаж, 5128 иргэний өргөдлийг шийдвэрлэж, 345,86 га газрыг өмчлүүлээд байна.



СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС